



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/177

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 3/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд "COVID-19"-ын цар тахалын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн урьдчилан сэргийлэх, халдварыг илрүүлэх түргэн оношилгооны тестийг худалдан авах зардлын санхүүжилтэд нийт 100000000.00 төгрөг /нэг зуун сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 100.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 онд 4.27-д батлагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
3 дугаар сарын 30-ны өдрийн  
А/177 дугаар захирамжийн хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН  
ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ҮЕИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

ДД	Байгууллагын нэр	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
1	Аймгийн Эрүүл мэндийн газар	Хурдавчилсан оношлуурын тест	ш	5000	20000.00	100000.0
Дүн				5000	20000.00	100000.0

-oOo-